



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/67

Улаанбаатар хот

Иргэдийн бүлгийг бүртгэх, санхүүжилт олгох  
журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "ж" заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.4 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа материал худалдан авахад олон нийтийг оролцуулах зорилгоор "Иргэдийн бүлгийг бүртгэх, санхүүжилт олгох журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмын дагуу Иргэдийн бүлгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээнд оролцуулах, арга хэмжээ авч ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Ганхуяг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАТБИЛЭГ

2179190173

Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 07 дугаар  
сарын 25 -ны өдрийн А/67 дугаар тогтоолын  
хавсралт



## **ИРГЭДИЙН БҮЛЭГ БҮРТГЭХ, САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ЖУРАМ**

### **Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль/ цаашид хууль гэх/-ийн 7.1 дүгээр заасны дагуу сум, дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах хорин сая хүртэлх төгрөгийн өртөгтэй бараа, ажил үйлчилгээ худалдан авахад оролцох иргэдийн бүлгийг бүртгэх, санхүүжилтийг олгоход энэхүү журмын зорилго оршино.

1.2. Олон нийтийн оролцоотой бараа, ажил үйлчилгээ худалдан авах гүйцэтгэлийг сонгон шалгаруулахад Сангийн сайдын 2012 оны 02 дугаар сарын 21 өдрийн 39 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны жишиг баримт бичгийг, иргэдийн бүлгийг бүртгэх, санхүүжилтийг олгоход Хан Уул дүүргийн Засаг даргын тамгын газрын олон нийтийн оролцоотой иргэдийн бүлэг байгуулах, санхүүжилт олгох жишиг баримт бичгийг хэрэглэнэ.

1.3 Энэхүү журмаар зохицуулагдаагүй харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль түүнд нийцүүлэн батлагдан гарсан заавар, журмын дагуу зохицуулна.

### **Хоёр. Олон нийтийн худалдан авах ажиллагаанд иргэдийн бүлгийг бүртгэх**

#### **2.1 Иргэдийн бүлэгт тавигдах шаардлага**

- 2.1.1 Иргэдийн бүлэг нь 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 2.1.2 Бүлгийн гишүүд нь тухайн хороонд 6 сараас доошгүй хугацаанд оршин суусан байна
- 2.1.3 Бүлгийн ахлагч хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байна
- 2.1.4 Тухайн хорооны Иргэдийн нийтийн хурал эсвэл Тэргүүлэгчдийн хурал мөн хорооны Засаг даргаар дэмжигдсэн байх

- 2.1.5 Нэг иргэн нэг иргэдийн бүлэгт харьяалагдах ба иргэдийн бүлгийг бүртгэх мэргэжилтэн иргэдийн бүлгийн гишүүдийн давхцлыг хянасан байх
- 2.1.6 Бүлгийн ахлагч, дэд ахлагч "Татвар төлөгч иргэний орлого,Татварын бүртгэлийн дэвтэр"-тэй байна.  
Бусад гишүүд ийм дэвтэртэй байж болно.
- 2.1.7 Иргэдийн бүлэг нь оноосон нэртэй байна.
- 2.1.8 Тухайн ажлыг гүйцэтгэхэд иргэдийн бүлгийн 1-2 гишүүд нь мэргэшсэн байх
- 2.1.9 Иргэдийн бүлгийн гишүүдэд нэг өрхөөс 2-оос дээш хүн оролцуулахгүй байх

2.2 Иргэдийн бүлгийг тус дүүргийн Засаг даргын Тамгын газарт дараах бичиг баримтыг бүрдүүлэн бүртгүүлнэ. Үүнд:

- 2.2.1 Бүлгийн гишүүдийн " Иргэдийн бүлэг" байгуулах тухай хурлын тэмдэглэл /гарын үсгээр баталгаажсан байх/
- 2.2.2 Иргэдийн бүлгийн гишүүд ахлагчтайгаа байгуулсан "Хамтран ажиллах гэрээ" /нотариатаар батлуулсан байх/
- 2.2.3 Тухайн хорооны Иргэдийн Нийтийн хурал эсвэл Тэргүүлэгчдийн хурлаас бүлэг дэмжсэн тухай тогтоол /хурлын тэмдэглэлийн хамт/
- 2.2.4 Тухайн хорооны Засаг даргаас Иргэдийн бүлгийг дэмжсэн тухай тодорхойлолт
- 2.2.5 Тухайн хорооны Иргэдийн Нийтийн хурлын даргын тодорхойлолт
- 2.2.6 Бүлгийн ахлагч, дэд ахлагчийн харилцагч банкны данс эзэмшигчийн тодорхойлолт
- 2.2.7 Бүлгийн гишүүдийн "Татвар төлөгч иргэний орлого,Татварын бүртгэлийн дэвтэр"-ийн хуулбар
- 2.2.8 Бүлгийн гишүүдийн оршин суугаа хорооны тодорхойлолт
- 2.2.9 Бүлгийн гишүүдийн анкет

2.3 Иргэдийн бүлэг нь ахлагч, дэд ахлагчийг дотроосоо томилсон хурлын шийдвэр байна.

2.4 Бүлгийн гишүүд Сангийн сайдын 2013 оны 39 дугаар тушаал 2 дугаар хавсралтыг үндэслэн хоорондын хамтран ажиллах гэрээг байгуулна.

2.5 Энэхүү журмын 2.2 дахь заалтын шаардлагыг хангаж бүртгүүлсэн Иргэдийн бүлэгт бүртгэлийн гэрчилгээ олгох бөгөөд гэрчилгээнд бүлгийн гишүүдийн мэдээллийг тэмдэглэж, ЗДТГ-ын Захиргаа, хуулийн хэлтсийн дарга гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Бүртгэлийн гэрчилгээ нь Нэг жилийн хугацаатай байх бөгөөд хугацааг дахин сунгаж болно.

2.6 Иргэдийн бүлэгт гишүүд нэмж орох, хасагдах тохиолдолд бүртгэлийн гэрчилгээнд гишүүдийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг бүлгийг бүртгэсэн мэргэжилтнээр тэмдэглүүлнэ.

### **Гурав. Иргэдийн бүлэгт санхүүжилт олгох**

3.1 Иргэдийн бүлэг нь бараа, ажил гүйцэтгэх гэрээ байгуулсны дараа ажлын 5 /тав/ хоногийн дотор нийт гэрээний үнийн дүнгийн 30 хүртэлх хувийн санхүүжилтийг тухайн хорооны Засаг даргын албан тоотыг үндэслэн бүлгийн ахлагчийн дансанд шилжүүлнэ.

3.2 Бараа материал, цалингийн санхүүжилтэд бүлгийн гишүүд өөрсдөө хяналт тавина.

3.3 Ажлын гүйцэтгэлийн явцад Техник хяналтын комиссын акт, дүгнэлтийг үндэслэн дараагийн санхүүжилтийг олгоно.

3.4 Үе шатны санхүүжилт авахад шаардагдах баримт бичигт дараах зүйлс заавал орно. Үүнд:

3.4.1 Гүйцэтгэл /сангийн сайдын 2012 оны 290 тоот тушаалын хавсралт №3А хүснэгт/

3.4.2 Гүйцэтгэлийн дэлгэрэнгүй тайлан

3.4.3 Гэрээний хуулбар

3.4.4 Зураг /өнгөтөөр тайлбартай/

3.4.5 Техник хяналтын комиссын акт, хурлын тэмдэглэл

3.4.6 Талбайн ажлын журнал

3.4.7 Нэхэмжлэл

3.4.8 Хяналтын хуудас

3.4.9 Шаардлагатай бол ил далд ажлын акт/ техникийн комиссын гишүүдээр баталгаажуулсан байх/



## Тав. Хариуцлага

5.1 Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа энэхүү журмын зүйл заалтыг зөрчсөн этгээдэд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага ногдуулна.

5.2 Тухайн иргэдийн бүлгийн ахлагч ажил гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд дэд ахлагч ажлыг хариуцан гэрээний хугацаанд ажлыг хүлээлгэн өгнө.

5.3 Тухайн иргэдийн бүлгийн ахлагч ажил гүйцэтгэх боломжгүй болсон нь гэрээний хугацаа сунгах, цуцлах, ажлыг зогсоох, түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.

5.4 Санаатай болон санамсаргүй байдлаас болж гэрээний хугацаанд ажлаа дуусгаагүй тохиолдолд шалтгааныг албан ёсоор дүүргийн Засаг даргын Захирамжаар байгуулагдсан техник хяналтын ажлын хэсэгт мэдэгдэнэ.

5.5 Шаардлага хангахгүй ажил гүйцэтгэсэн иргэдийн бүлгийн ахлагч, дэд ахлагчийг 2 жил, гишүүдийг нэг жилийн хугацаанд иргэдийн бүлгийн бүртгэлд бүртгэхгүй.

5.6 Тухайн хорооны Засаг дарга, Иргэдийн нийтийн хурлын дарга тухайн ажил үйлчилгээний тоо хэмжээ, байршил, чанар байдалд өөрчлөлт хийх эрх эдлэхгүй.

5.7 Тус журмын 5.6 заалтыг зөрсөн Хорооны засаг дарга, Иргэдийн нийтийн хурлын даргад үүнээс үүдэн гарах зардлыг төлүүлэх хариуцлагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээлгэнэ.

5.8 Талуудын хооронд санхүүжилттай холбогдсон маргаан үүсвэл Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.